



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/110/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Баянхонгор хот 2022 оны 02 дугаар сар</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер А.Цээням Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор М.Алтантуяа Утас: 80112188 Цахим хаяг: myangnboom@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор Б.Должмаа Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа	15
4.2 Төлбөрийн акт	15
4.3 Албан шаардлага	16
4.4 Зөвлөмж	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584

E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.22 № 2/57

Г
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗООНОЗЫН
ӨВЧИН СУДЛАЛЫН ТӨВИЙН
ДАРГА Б.АЛТАНЧИМЭГ ТАНАА

танай _____ -ны № _____ -т

Г
АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол дагуу Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн санхүүгийн тайланд 2017 онд албан хаагчдаар төлүүлсэн 1,331.5 мянган төгрөгийн бараа материал бүртгэлтэй, аудитаар нийт 107,248.0 мянган төгрөгийн алдаа илэрсэн нь аудитаар тооцсон материаллаг байдлаас хэтэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1, 13 дугаар зүйлийн 13.4 дэх заалттай нийцэхгүй, Оршин байх, Үнэн зөв байдлын батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

005020345

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

**Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	34,801,317.65	32,922,967.35
35	БАРАА МАТЕРИАЛ	34,801,317.65	32,922,967.35
351	Түүхий эд материал	24,278,351.04	22,194,034.74
35110	Тусгай зориулалттай материал	10,715,267.00	11,684,267.00
35130	Эм боох материал	13,563,084.04	10,509,767.74
354	Хангамжийн материал	10,522,966.61	10,728,932.61
35410	Бичиг хэргийн материал	1,936,900.00	2,165,640.00
35420	Аж ахуйн материал	4,400,189.09	5,374,659.09
35440	Түлш, шатах тослох материал	196,977.52	1,113,033.52
35450	Барилгын засварын материал	591,900.00	518,100.00
35470	Бусад хангамжийн материал	3,397,000.00	1,557,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	997,492,201.74	1,039,519,154.01
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	997,492,201.74	1,039,519,154.01
392	Биет хөрөнгө	801,492,201.74	843,519,154.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	774,922,814.33	784,675,084.33
39202	Хуримтлагдсан элэгдэл	-43,302,885.28	-60,204,797.92
39203	Авто-тээврийн хэрэгсэл	58,700,000.00	100,850,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-30,612,500.00	-34,794,166.68
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	133,535,692.08	145,414,181.18
39206	Хуримтлагдсан элэгдэл	-104,306,236.51	-110,920,749.89
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,237,838.00	24,988,238.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-10,053,725.29	-12,197,017.90
39214	Бусад үндсэн хөрөнгө	24,836,417.80	24,836,417.80
39215	Хуримтлагдсан элэгдэл	-17,465,213.39	-19,128,034.91
393	Биет бус хөрөнгө	196,000,000.00	196,000,000.00
39301	Програм хангамж	869,000.00	869,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-869,000.00	-869,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	196,000,000.00	196,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,032,293,519.39	1,072,442,121.36
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	1,145,781.56
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	1,145,781.56
413	Өглөг	00.00	1,145,781.56
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	556,738.36
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	371,293.20
4136	Бусад өглөг	00.00	217,750.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	67,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	150,750.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,032,293,519.39	1,071,296,339.80
51	Засгийн газрын хувь оролцоо	1,032,293,519.39	1,071,296,339.80
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	427,624,333.39	427,624,333.39
51101	Өмч: - төрийн	427,624,333.39	427,624,333.39
512	Хуримтлагдсан үр дүн	538,188,270.90	577,191,091.31
51210	Өмнөх үеийн үр дүн	538,188,270.90	536,856,770.90
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	40,334,320.41
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	66,480,915.10	66,480,915.10
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,032,293,519.39	1,072,442,121.36

**Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	487,892,204.50	684,501,918.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,001,004.50	79,266,124.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,259,777.00	79,266,124.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,259,777.00	79,266,124.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,259,777.00	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		59,852,670.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		15,482,354.00
122	Тусламжийн орлого	2,741,227.50	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	2,741,227.50	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	479,891,200.00	605,235,794.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	479,891,200.00	509,439,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	479,891,200.00	509,439,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	95,796,494.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	9,752,270.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	86,044,224.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	514,989,589.92	644,167,597.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	514,989,589.92	644,167,597.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	509,143,099.52	631,383,500.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	344,129,934.22	351,727,834.40
210101	Үндсэн цалин	225,289,951.87	189,236,503.00
210102	Нэмэгдэл	75,521,107.54	129,161,529.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,261,183.98	11,990,948.80
210104	Урамшуулал	28,057,690.83	21,338,853.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,764,331.00	50,911,672.33
210201	Тэтгэврийн даатгал	31,142,198.00	33,319,566.87
210202	Тэтгэмжийн даатгал	6,220,414.00	5,493,106.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,044,081.00	4,565,370.74
210204	Ажилгүйдлийн даатгал	668,783.00	684,657.03
210205	Эрүүл мэндийн даатгал	6,688,855.00	6,848,970.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,256,770.13	34,128,712.00
210301	Гэрэл, цахилгаан	2,416,397.13	1,714,552.00
210302	Түлш, халаалт	30,623,673.00	31,363,760.00
210303	Цэвэр, бохир ус	1,216,700.00	1,050,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,203,195.25	21,069,114.00
210401	Бичиг хэрэг	2,896,900.00	1,460,660.00
210402	Тээвэр, шатахуун	6,638,663.00	15,939,898.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,419,343.25	1,166,956.00
210404	Ном, хэвлэл	00.00	125,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	113,250.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,048,289.00	2,263,350.00
2105	Нормативт зардал	18,364,182.15	32,333,916.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,868,684.15	29,719,916.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,495,498.00	2,614,000.00

**Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,142,680.00	8,525,507.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,112,680.00	1,554,297.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	1,300,000.00
210604	Урсгал засвар	5,030,000.00	5,671,210.00
2107	Томилолт, зочны зардал	3,078,000.00	3,928,000.00
210702	Дотоод албан томилолт	3,078,000.00	3,928,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,798,360.00	96,632,127.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	89,015,185.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	170,000.00	170,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	430,000.00	430,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	145,860.00	206,512.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,213,500.00	5,926,130.00
210807	Газрын төлбөр	784,000.00	784,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	45,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,405,646.77	32,126,617.73
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	36,405,646.77	32,126,617.73
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,846,490.40	12,784,096.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	483,000.00	380,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	483,000.00	380,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,363,490.40	12,404,096.63
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,363,490.40	12,404,096.63
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-27,097,385.42	40,334,320.41
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,307,594.29	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	609,594.29	00.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	698,000.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-1,307,594.29	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-28,404,979.71	40,334,320.41

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	427,624,333.39	66,483,487.00	566,590,678.72	1,060,698,499.11
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	427,624,333.39	66,483,487.00	566,590,678.72	1,060,698,499.11
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-28,404,979.71	-28,404,979.71
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	427,624,333.39	66,480,915.10	538,188,270.90	1,032,293,519.39
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	427,624,333.39	66,480,915.10	538,188,270.90	1,032,293,519.39
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-1,331,500.00	-1,331,500.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	427,624,333.39	66,480,915.10	536,856,770.90	1,030,962,019.39
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	40,334,320.41	40,334,320.41
D09	2012 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	427,624,333.39	66,480,915.10	577,191,091.31	1,071,296,339.80

**Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	479,891,200.00	605,235,794.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	479,891,200.00	605,235,794.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	479,891,200.00	509,439,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	479,891,200.00	509,439,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	95,796,494.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	9,752,270.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	86,044,224.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	479,891,200.00	594,865,994.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	479,891,200.00	594,865,994.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	474,044,709.60	582,081,897.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	343,735,281.22	351,540,768.40
210101	Үндсэн цалин	224,274,202.87	187,789,457.00
210102	Нэмэгдэл	83,910,735.54	129,161,529.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,352,273.98	13,261,172.80
210104	Урамшуулал	20,198,068.83	21,328,609.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,375,190.00	49,460,777.97
210201	Тэтгэврийн даатгал	33,204,557.00	33,540,799.06
210202	Тэтгэмжийн даатгал	3,768,914.00	3,952,748.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,044,081.00	4,537,505.57
210204	Ажилгүйдлийн даатгал	668,813.00	675,211.29
210205	Эрүүл мэндийн даатгал	6,688,825.00	6,754,513.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,256,770.13	34,128,712.00
210301	Гэрэл, цахилгаан	2,416,397.13	1,714,552.00
210302	Түлш, халаалт	30,623,673.00	31,363,760.00
210303	Цэвэр, бохир ус	1,216,700.00	1,050,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,769,158.25	19,979,733.00
210401	Бичиг хэрэг	2,730,600.00	1,640,900.00
210402	Тээвэр, шатахуун	5,000,000.00	15,360,307.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,324,193.25	1,186,956.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,345,715.00	116,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,368,650.00	1,675,570.00
2105	Нормативт зардал	17,575,300.00	15,012,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,702,300.00	12,522,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,873,000.00	2,490,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,632,500.00	10,322,757.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,939,100.00	3,894,997.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,333,400.00	1,333,300.00
210604	Урсгал засвар	5,360,000.00	5,094,460.00
2107	Томилолт, зочны зардал	3,078,000.00	3,928,000.00

**Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210702	Дотоод албан томиллолт	3,078,000.00	3,928,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,622,510.00	97,708,549.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	94,972,537.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	170,000.00	170,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	430,000.00	430,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	145,860.00	206,512.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,037,650.00	1,050,000.00
210807	Газрын төлбөр	784,000.00	784,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	40,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,846,490.40	12,784,096.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	483,000.00	380,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	483,000.00	380,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,363,490.40	12,404,096.63
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,363,490.40	12,404,096.63
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	10,369,800.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	10,369,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	10,369,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	10,369,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	10,369,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-10,369,800.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	509,439,300.00	497,859,160.37	11,580,139.63	97.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	509,439,300.00	497,859,160.37	11,580,139.63	97.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	508,859,300.00	497,479,160.37	11,380,139.63	97.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	353,060,800.00	351,540,768.40	1,520,031.60	99.57
210101	Үндсэн цалин	240,019,500.00	187,789,457.00	52,230,043.00	78.24
210102	Нэмэгдэл	56,941,400.00	129,161,529.00	-72,220,129.00	226.83
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,097,000.00	13,261,172.80	6,835,827.20	65.99
210104	Урамшуулал	36,002,900.00	21,328,609.60	14,674,290.40	59.24

**Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,193,800.00	49,460,777.97	1,733,022.03	96.61
210201	Тэтгэврийн даатгал	33,540,800.00	33,540,799.06	0.94	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,530,600.00	3,952,748.97	-422,148.97	111.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,355,100.00	4,537,505.57	1,817,594.43	71.40
210204	Ажилгүйдлийн даатгал	706,100.00	675,211.29	30,888.71	95.63
210205	Эрүүл мэндийн даатгал	7,061,200.00	6,754,513.08	306,686.92	95.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,558,900.00	34,128,712.00	2,430,188.00	93.35
210301	Гэрэл, цахилгаан	2,242,600.00	1,714,552.00	528,048.00	76.45
210302	Түлш, халаалт	32,431,400.00	31,363,760.00	1,067,640.00	96.71
210303	Цэвэр, бохир ус	1,884,900.00	1,050,400.00	834,500.00	55.73
2104	Хангамж, бараа материалын зардал	26,201,000.00	25,079,733.00	1,121,267.00	95.72
210401	Бичиг хэрэг	1,502,500.00	1,640,900.00	-138,400.00	109.21
210402	Тээвэр, шатахуун	15,763,300.00	15,360,307.00	402,993.00	97.44
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	685,200.00	1,186,956.00	-501,756.00	173.23
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,400,000.00	116,000.00	1,284,000.00	8.29
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,850,000.00	6,775,570.00	74,430.00	98.91
2105	Нормативт зардал	18,630,600.00	15,012,600.00	3,618,000.00	80.58
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,130,600.00	12,522,600.00	2,608,000.00	82.76
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,500,000.00	2,490,000.00	1,010,000.00	71.14
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,410,000.00	15,592,557.00	817,443.00	95.02
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,300,000.00	9,164,797.00	135,203.00	98.55
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,000,000.00	1,333,300.00	666,700.00	66.67
210604	Урсгал засвар	5,110,000.00	5,094,460.00	15,540.00	99.70
2107	Томилолт, зочны зардал	3,928,000.00	3,928,000.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	3,928,000.00	3,928,000.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,876,200.00	2,736,012.00	140,188.00	95.13
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	170,000.00	170,000.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	430,000.00	430,000.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	237,200.00	206,512.00	30,688.00	87.06
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	55,000.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,050,000.00	1,050,000.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	784,000.00	784,000.00	0.00	100.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	150,000.00	40,500.00	109,500.00	27.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	580000.00	380000.00	200,000.00	65.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	580,000.00	380,000.00	200,000.00	65.52
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	580,000.00	380,000.00	200,000.00	65.52
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	509,439,300.00	497,859,160.37	11,580,139.63	97.73
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	509,439,300.00	497,859,160.37	11,580,139.63	97.73
131001	Улсын төсвөөс санхүүжих	509,439,300.00	497,859,160.37	11,580,139.63	97.73
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	28.00	28.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	28.00	28.00	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	29.00	29.00	0.00	100.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	19.00	19.00	0.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10.00	10.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	95,796,494.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	95,796,494.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	95,796,494.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	95,796,494.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	95,796,494.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	95,796,494.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	95,796,494.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,752,270.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	86,044,224.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгийн ангиллыг зөв бүртгэж, хөрөнгийн тооллогыг жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахын өмнө явуулах, даргын тушаалын дагуу хөрөнгийг актлах зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 08 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг С.Баасанхүү, 2 дугаар гарын үсгийг Б.Мөнхзул нар зурж, нярваар Ч.Отгонтөгс ажиллажээ.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төв нь 2021 онд "Салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх" зорилт дэвшүүлэн, Эрүүл мэндийн яам, Зоонозын өвчин судлалын үндэсний төв, аймгийн Эрүүл мэндийн газраас жил бүр дэвшүүлэн тавьсан зорилго зорилтыг хангах үүднээс байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийн дагуу 29 орон тоотой үйл ажиллагаа явуулжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит гүйцэтгээгүй, бусад хяналт шалгалтын байгууллагуудаас шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийг "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн зардлын 514,989.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 7,724.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,407.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн зардлын 573,430.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,601.5 мянган төгрөгөөр, 6,021.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 6,021.0 мянган төгрөг байгаа тул материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1,451,888.9 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 694,021.1 мянган төгрөгөөр буюу 191.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, авлагын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	3	5
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	34,801.3	32,923.0	(1,878.4)
Бараа материал	34,801.3	32,923.0	(1,878.4)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	997,492.2	1,039,519.2	42,027.0
Үндсэн хөрөнгө	1,204,101.8	1,277,632.9	73,531.2
Хуримтлагдсан элэгдэл	(206,609.6)	(238,113.8)	(31,504.2)
Нийт хөрөнгө	1,032,293.5	1,072,442.1	40,148.6
Өр төлбөр	-	1,145.8	1,145.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,032,293.5	1,071,296.3	39,002.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,032,293.5	1,072,442.1	40,148.6

Эх сурвалж: Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан

Тус байгууллагын төрийн сан банкны 2 харилцах данс оны эцэст үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 32,923.0 мянган төгрөг болж өмнөх оноос 1,878.4 мянган төгрөгөөр буурсан ба тайлант онд төсвийн хөрөнгөөр 44,732.4 мянга, төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар 15,482.3 мянган төгрөгийн бараа материалыг хүлээн авч, үйл ажиллагаандаа 56,541.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулан, байгууллагын даргын 2021 оны А/13, А/42, А/48 дугаар тушаалаар 5,551.6 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийг акталсан байна.

Оны эхэнд бүртгэлтэй 1,204,101.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө дээр нэмж төсвийн хөрөнгөөр 20,122.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, аймгийн Засаг даргын 2021.08.18-ний өдрийн А/516 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 39,500.0 мянган төгрөгийн ариутгал халдваргүйтэлд ашиглах автомашин худалдан авч өгсөн байна. Аймгийн ЗДТГ-аас мотоцикл, бууг үнэ төлбөргүй өгч, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 45 дугаар тогтоолоор аймгийн Эрүүл мэндийн газраас 2,420.4 мянган төгрөгийн ширээ сандал балансаас баланст шилжүүлж, ИТХ-ын 43 дугаар тогтоолоор 633.4 мянган төгрөгийн 2 хөрөнгийг акталжээ.

Аудитаар 482.3 мянган төгрөгийн өглөгийг залруулж, оны эцэст 1,145.8 мянган төгрөгийн өглөгтэй гарсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 40,334.3 мянган төгрөгөөр нэмэгдэж 1,071,296.3 мянган төгрөг болсон байна.

Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төв улсын төсвөөс авах санхүүжилт санхүүжилт өмнөх оноос 29,548.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, 509,439.2 мянган төгрөг болсон ба санхүүжилтийг бүрэн авч, үйл ажиллагаандаа батлагдсан төсвийн 97.7 хувь буюу 497,859.1 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 11,580.1 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн 1,331.5 мянган төгрөгөөр буурч, 536,856.8 мянган төгрөг болсон нь 2017 онд албан хаагчдаар төлүүлсэн хувцсыг бараа материалаас хасаагүй үлдэгдлээр явсан зөрчил илэрч, аудитаар залруулсан болно.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төв 2021 оны төсвийн төлөвлөлтийг 617,357.7 мянган төгрөгөөр төлөвлөж, аймгийн Эрүүл мэндийн газарт хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71601 хөтөлбөрийн 80101 арга хэмжээг санхүүжүүлэх төсвийн хуваарийг анх 498,839.3 мянган төгрөгөөр баталжээ. Оны эцэст түлш халаалт, нормын хувцас болон хөдөлмөр хамгааллын хэрэгсэл худалдан авах зардлын хэмнэлтийг эмийн зардалд гүйлгэн зарцуулах, бага үнэтэй, түргэн элэгдэх аж ахуйн зүйлс, багаж техник хэрэгсэл худалдан авах зардлыг нэмэгдүүлж, төсвийг 10,600.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 509,439.3 мянган төгрөгийн төсөв оны эцэст баталсан байна

Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төв тайлант онд улсын төсвөөс авахаар батлагдсан 509,439.3 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, 497,859.2 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, оны эцэст 11,580.1 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Эрүүл мэндийн газраас 86,044.2 мянга, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас 9,752.3 мянга, нийт 95,796.5 мянган төгрөгийн орлого орсноос 94,972.6 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 823.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Оны эцэст төсвийг нэмж тодотгон бага үнэтэй, түргэн элэгдэх аж ахуйн зүйлс авах зардалд 4,600.0 мянган төгрөг нэмж тодотгосноор 3 ширхэг хээрийн майхан худалдан авсан, багаж техник хэрэгсэл худалдан авах зардалд 3,300.0 мянган төгрөг нэмж тодотгосноор “Некст электроникс” ХХК-аас зөөврийн компьютер худалдан авч, хөрөнгөд бүртгэсэн байна.

Аймгийн ОНХС-аас 9,752.3 мянган төгрөгийн орлогыг шилжүүлж, байгууллагын цэвэр бохир усны шугамыг засварласныг “Сүндэр констаркшн” ХХК гүйцэтгэсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 63 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснийг аймгийн Эрүүл мэндийн газраас 84.1 хувиар үнэлжээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 753,374.0 мянган төгрөгийн 89 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод мэдээлэхийг бүрэн мэдээлсэн, мэдээлбэл зохих 148 мэдээллээс 578,776.6 мянган төгрөгийн 135 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 13 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлж, 86,280.8 мянган төгрөгийн 12 мэдээллийг мэдээлээгүй орхигдуулсан байна.

Хүснэгт 2. Шилэн дансанд байршуулсан мэдээлэл

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон
1	Бүтэн жил	8	8	6	2
2	Хагас жил	4	4	4	0
3	Улирал бүр	1	4	4	0
4	Сар бүр	3	36	33	3
5	Тухай бүр	8	96	88	8
	Нийт	24	148	135	13

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн шилэн данс

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, ТБОНӨХБАҮХАТХ болон Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын зарим чиглэлийг хэрэгжүүлж ажиллаагүй нь холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэн зөвлөмжийг хүргүүлэв.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа гүйцэтгэж, 1,725.3 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 3 зөвлөмж өгсөн байна. Албан хаагчдаас төлбөрийн актыг суутган тооцож, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн, өмнөх аудитаар зөвлөмжөөр өгсөн алдаа 2021 оны санхүүгийн тайланд дахин илэрсэнд бараа материалын зардалд санхүүгийн тайланд залруулга хийж, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангалтгүй биелүүлсэн зөрчилд албан шаардлага өглөө.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал Байхгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 107,248.0 мянган төгрөгийн 11 алдаа зөрчил илэрснээс, 15,128.6 мянган төгрөгийн 5 алдааг санхүүгийн тайланд залруулж, 2 зөрчилд 737.3 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 90,910.6 мянган төгрөгийн 2 албан шаардлага өгч, 471.5 мянган төгрөгийн зөрчилд байгууллагын удирдлагад 2 зөвлөмжийг хүргүүлэв.

4.1 Залруулсан алдаа

Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн санхүүгийн тайланд нийт 15,128.6 мянган төгрөгийн залруулгыг хийлээ. Үүнд:

1. Бусад хангамжийн бараа материалын тайланд бүртгэлтэй 1,841.5 мянган төгрөгийн бараа материалыг оны эцэст тоолоогүйг тодруулан шалгахад 2017 онд төрийн аудитын байгууллагын төлбөрийн актаар тогтоосон 1,331.5 мянган төгрөгийн биеийн тамирын хувцсыг албан хаагчдаар төлүүлсэн байхад нягтлан бодогч Т.Одонтуяа бараа материалаас хасаагүй байна.
2. Эрүүл мэндийн сайдын 2021.12.23-ний өдрийн А/799 дүгээр тушаалаар "Бүсийн оношилгоо, эмчилгээний төвүүдийн эмнэлгийн тусламж, үйлчилгээний чадавхыг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээ"-ний хүрээнд Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн бэлэн байдлыг хангах зорилгоор нэг бүр нь 1,965.5 мянган төгрөгийн үнэ бүхий 2 ширхэг суурин компьютерийг олгосон байхад хөрөнгөд бүртгээгүй байна.
3. Эм боох материалын тайланг 94.2 мянга, шатахууны тайланг 156.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.
4. Албан хаагчдаас суутгасан үйлдвэрчний эвлэлийн татварыг 317.7 мянга, хамтын сангийн суутгалыг 10.0 мянган төгрөгийг шилжүүлээгүй атлаа санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй байна.
5. Үндсэн хөрөнгийн 10,11,12 дугаар сарын элэгдлийн бодуулаагүйгээс тайлант жилийн элэгдлийн зардлыг 9,131.3 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд 15,128.6 мянган төгрөгийг залруулав.

4.2 Төлбөрийн акт

1. Эрүүл мэндийн сайдын 2021.07.26-ний өдрийн А/496 дугаар тушаалаар короновируст халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу хэмжээнд ажилласан эрүүл мэндийн салбарын албан хаагчдыг урамшуулах зорилгоор олгосон нэг удаагийн тэтгэмжийг бичиг хэргийн ажилтны орон тоон дээр ажилласан 2 албан хаагчид 583.3 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2. Баянхонгор аймгийн Шүүхийн Тамгын газрын нягтлан бодогч Б.Мөнхзул ХХОАТ-ын хөнгөлөлтийг авсан байхад Зоонозын өвчин судлалын төвийн нягтлан бодогчоор ажиллахдаа 153.9 мянган төгрөгийн ХХОАТ-ын хөнгөлөлтийг давхардуулан авсан байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх "Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

4.3 Албан шаардлага

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан аймгийн ЭМГ-аас олгосон 5 удаагийн 86040.8 мянган төгрөгийн орлого, түүний зардлыг мэдээлээгүй, байгууллагын даргын 2021.05.17-ний өдрийн 40.0 мянга, 2021.09.29-ний өдрийн 200.0 мянган төгрөгийн хөрөнгө захиран зарцуулах тушаалыг байршуулаагүй, Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 дахь "Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

2. Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2021.07.21-ний өдрийн А/83 дугаар тушаалаар Зоонозын өвчин судлалын төвийн халдвар судлаач А.Гончигсумлаа, жолооч О.Ган-Эрдэнэ нарт 2,992.3 мянган төгрөгийн илүү цагийн хөлс, хоолны мөнгө олгохдоо нийгмийн даатгал, татварыг суутган тооцсон атлаа цалинг нийгмийн даатгал, татварын мэдээнд мэдээлээгүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15 дахь "Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 4 дэх хэсэгт заасан даатгуулагч болон ажил олгогч нь дор дурдсан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх "Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Балансын данстай холбоотой асуудал**

1.1. **Илрүүлэлт:** Эд хөрөнгийн тооллогыг байгууллагын даргын 2021.11.22-ний өдрийн А/44 дугаар тушаалаар хийж, жилийн эцэст санхүүгийн тайлан гаргахын өмнө хийгээгүй байна.

1.2. **Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 дэх "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгө, төлбөр тооцооны авлагыг заавал хийнэ" гэснийг хэрэгжүүлж, тооллогыг нүд үзэн тоолж, тооллогын дүнд үндэслэн тооцоо бодсон актыг үйлдэж, санхүүгийн баримтад хавсаргах.

2. **Зардлын холбоотой асуудал**

**Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2.1. Илрүүлэлт: Байгууллагын даргын 2021.03.05-ний А/13 дугаар тушаалаар эмийн сангаас 618.5 мянган төгрөгийн өртөг бүхий эргэлтийн хөрөнгө актлах шийдвэр гарсан байхад 317.0 мянган төгрөгийн эмийг акталж, 301.5 мянган төгрөгийн эмийг актлаагүй, даргын 2021.12.13-ний өдрийн А/48 дугаар тушаалаар 2 нэр төрлийн 170.0 мянган төгрөгийн эмийг актлах шийдвэр гарсан байхад хөрөнгөөс хасаагүй, даргын шийдвэрийг хэрэгжүүлээгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл эд хөрөнгийн тооллого, зарцуулахтай холбоотой шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/мянган төгрөгөөр/							
				Залруулга				Төлбөрийн акт			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төв	11	107,248.0	5	15,128.60	2	737.3	2	90,910.6	2	471.5

---oOo---